

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9	Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12.	Шилэн дансны мэдээлэл	8
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	12
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	14
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.БАНЗРАГЧ ТАНАА

2020.03.13 № 06/864
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн захирал Л.Банзрагч танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, анхан шатны баримтыг бүрдлийг хангах, зардлыг үнэн зөв ангилах, дотоод хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 09-с 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-ийн Менежер Д.Хишгээ анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлэхээр багийн ахлагч, аудитор Д.Баатарсайхан, аудитор Ж.Ням-Осор, аудиторын туслах Ч.Энхзаяа нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн 01/62 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн эрхэм зорилго нь 2019 онд орлого нэмэгдүүлэх хэрэглэгчдийг найдвартай цахилгаан болон дулааны эрчим хүчээр хангах гэж тодорхойлон ажиллажээ.

Энэ зорилтын хүрээнд 2019 оноос эхлэн Төвийн бүсийн нэгдсэн системд цахилгаан эрчим хүч нийлүүлдэг болсноор орлого нэмэгдэж хэрэглэгчдийг цахилгаан болон дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах үүргээ биелүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд хугацаанд Нийгмийн даатгалын хуулинд шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хувьд өөрчлөлт орсныг мөрдөн ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Апекс” программ хангамж ашигладаг байна.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд 16 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг, хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгосон нь байгууллагын үйл ажиллагааны ажлын бодит цар хүрээ хэмжээг илэрхийлж байгаа тул зохимжтой гэж үзэв.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тус байгууллагын санхүүгийн ажилтнууд тогтвор суурьшилтай, сүүлийн 3 жилийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан зэргийг харгалзан эрсдэлийг дунд гэж үнэлэн сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 6,522.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 65.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,397.1 сая төгрөгөөр буюу 36.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	31.1	7.6	-23.5
Авлага	272.5	218.2	-54.3
Урьдчилгаа	958.1	902.5	-55.6
Бараа материал	408	610	202.0
Үндсэн хөрөнгө	11,074.2	11,217.2	143.0
Нийт хөрөнгө	12,743.9	12,955.5	211.6
Өр төлбөр	9,941.1	11,140.8	1199.7
Эздийн өмч	2,802.7	2,802.7	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,743.8	13,943.5	1199.7

Авлага дансны үлдэгдлийн бууралтад “ДҮТ” ХХК-иас ЦЭХ-ний түгээлтээс 91.5 сая төгрөгийн авлагатай байсан нь барагдсан нь байна. Нийт авлагын 80 %-ийг харилцагчдаас, 8.0 хувийг ААНБ-аас, 7.0 хувийг айл өрхөөс, 5.0 хувийг бусад авлага тус тус эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардал буурсан нь хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг капиталжуулж үндсэн хөрөнгө дансанд тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Баруун нарангийн уурхай зогсохтой холбоотойгоор нүүрс нөөц бүрдүүлсэн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтын ажлыг капиталжуулж данс бүртгэлд тусгасан нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өндөр байгаа нь нийт орлогын хэмжээ 922.1 сая төгрөгөөр тасалдаж, зардал 515.6 сая төгрөгөөр дутуу зарцуулж хэмнэлт үүссэн хэдий ч их засвар, хөрөнгө оруулалт ажлын санхүүжилтэд 508.7 сая төгрөг зарцуулж, мөнгөн хөрөнгийн чөлөөт урсгалд сөрөг нөлөө үзүүлснээс бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өглөг болон төсөвт байгууллагад төлөх өр төлбөрийн хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Даланзадгадын дулааны цахилгаан станц барих зорилгоор БНСУ-ын “Экспрот-Импорт” банкнаас Засгийн газар хоорондын дамжуулан зээлдэх гэрээгээр авсан жилийн 4 хувь хүүтэй 4,949.7 сая төгрөгийн үндсэн зээл, 1,096.3 сая төгрөгийн зээлийн хуримтлагдсан хүүгийн өглөг нийт 6,046.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн хугацаа дууссан байна.

2.9 Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны хурлаар дэмжигдэн Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 07 дугаар тушаалаар 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Тайлант онд зорилтот түвшнээр 6,322.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 7,038.9 сая төгрөгийн зардалтай, 716.5 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөжээ.

Тайлант онд 6,322.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,400.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 922.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Нийт орлогын төлөвлөгөө 922.1 сая төгрөгөөр тасарсан нь 2019 оны 02 дугаар сараас зуухны ул ширэмний томоохон гэмтэл үүсэж, цахилгаан эрчим хүчний түгээлт тасалдсанаас шалтгаалан 355.1 сая, тайлант онд хийгдэх их засвар, хөрөнгө оруулалтын ажлын удаашралтай холбоотойгоор 504.7 сая төгрөгөөр тус тус тасарсан нь нөлөөлсөн байна.

Дулааны эрчим хүчний орлого хэрэглэгчийн өсөлт болон тарифын нэмэгдлээс шалтгаалан 143.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Нийт 7,038.9 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 6,522.3 сая төгрөгийг зарцуулж, 516.6 сая төгрөг буюу 7.3 хувийн хэмнэлт гаргасан.

Цалинтай холбоотой зардал 172.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь үйлдвэрлэлийн доголдлоос дутуу түгээлт хийсэн тул сарын үр дүнгээр олгодог шагналт цалинг төлөвлөснөөс дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Ашиглалтын зардалд 111.7 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь цахилгаан эрчим хүчний тарифын нэмэгдлээс гадна эрчим хүчний дэмжих тарифаас шалтгаалсан байна.

Засвар үйлчилгээний зардал 288.0 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь ул ширэмний эвдрэлээс шалтгаалан, жилийн төлөвлөгөөнд зуух № 1, 2-ын их засварын ажлыг Эрчим хүчний яамны зөвшөөрлөөр ажлын даалгаврыг өөрчлөн “Ул ширэм шинэчлэх ажил” болгосон ба үүнтэй холбоотой бусад гэмтэл засах, урсгал засвар хийсэн нь шалтгаалсан байна.

Түлшний зардал /энерги/ 524.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь үйлдвэрлэлийн хэмжээ буурч нүүрс бага зарцуулснаас шалтгаалсан байна.

Гадны үйлчилгээний хөлс 55.3 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь мэргэжлийн хяналт болон бусад байгууллагуудын албан шаардлагаар гэрээт ажлууд хийгдсэнээс шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл тодорхойлоогүй бөгөөд нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 124.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, тайлагнасан 74.8 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 49.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Мөнгөн гүйлгээний тайланд 74.8 сая төгрөгийн зардлыг ангилал буруу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй алдааг санхүүгийн тайланд залруулсан болно.

Аудитаар нийт 49.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

БНСУ-ын “Экспрот-Импорт” банкнаас Засгийн газар хоорондын дамжуулан зээлдэх гэрээгээр авсан жилийн 4 хувь хүүтэй 4,949.7 сая төгрөгийн үндсэн зээл, 1,096.3 сая төгрөгийн хуримтлагдсан зээлийн хүүгийн өглөг нийт 6,046.0 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг төлөх эх үүсвэрийг хэрхэн шийдэгдэх нь анхаарал татахуйц асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар 7 төрлийн 62 мэдээлэл байршуулахаас 50 мэдээллийг хуулийн хугацаанд, 12 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж, 2 албан шаардлагын биелэлт 100 хувь байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй дүгнэлт”

Аудитаар залруулагдаагүй 49.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 65.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлого дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандард нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Бүртгэл тайланд тусгасан авлагын 21.5 сая төгрөгийн, өглөгийн 3.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл: Авлага, өглөгийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдэх, төлөгдөхгүй найдваргүй авлага үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллана

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Зардлыг буруу ангилж нүүрс тээврийн 18.9 сая төгрөгийн зардлыг нүүрсний өртөгт шингээж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 1.4-д “үнэн зөв байх”, 1.5-д “хэмжигдэхүйц байх”, 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл: Өртөг буруу тооцогдох.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 1.4-д "үнэн зөв байх", 1.5-д "хэмжигдэхүйц байх", 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруз сууриар хөтөлнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт" заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллана.

3.3 Дотоод аудит холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу 5.9 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, хөрөнгө шамшигдах.

3.3.3 Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл тайланд тусгаж байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн.

3.4 Дотоод хяналттай холбоотой

3.4.1 Илрүүлэлт: Шилэн дансанд тухай бүр байршуулах 62 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх.

3.4.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

<u>Үзүүлэлт</u>	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	31,097,141.07	7,648,049.96
Дансны авлага	272,477,689.25	218,158,622.71
Бараа материал	408,039,262.00	610,028,066.25
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	958,065,288.31	902,465,303.05
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,669,679,380.63	1,738,300,041.97
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	9,071,640,014.08	9,227,831,270.82
Биет бус хөрөнгө	1,656,036,379.00	1,656,036,379.00
Бусад эргэлтийн бус хөрөнгө	346,505,188.38	333,339,782.84
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,074,181,581.46	11,217,207,432.66
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,743,860,962.09	12,955,507,474.63
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	518,801,677.02	1,184,703,937.94
Цалингийн өглөг	321,840.78	1,287,677.93
Татварын өр	446,868,048.80	954,533,828.82
НДШ - ийн өглөг	224,262,157.76	413,598,504.72
Богино хугацаат зээл	5,087,763,654.92	5,086,015,455.16
Хүүний өглөг	1,087,039,716.79	1,096,275,294.27
Бусад богино хугацаат өр	881,356,415.82	851,397,154.01
Урьдчилж орсон орлого	1,338,043,505.43	1,196,318,499.23
Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,584,457,017.32	10,784,130,352.08
Урт хугацаат өр төлбөр		
Бусад урт хугацаат өглөг	356,654,135.00	356,654,135.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	356,654,135.00	356,654,135.00
Өр төлбөрийн нийт дүн	9,941,111,152.32	11,140,784,487.08
Эздийн өмч		
Өмч: Төрийн	8,337,595,020.45	8,337,595,020.45
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,808,076,252.49	4,808,076,252.49
Эздийн өмчийн бусад хэсэг	1,655,056,500.00	1,655,056,500.00
Хуримтлагдсан ашиг	(11,997,977,963.17)	(12,986,004,785.39)
Эздийн өмчийн дүн	2,802,749,809.77	1,814,722,987.55
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,743,860,962.09	12,955,507,474.63

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

<u>Үзүүлэлт</u>	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	2,667,684,309.45	3,029,993,503.97
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,496,507,743.47	5,493,177,287.04
Нийт ашиг (алдагдал)	(1,828,823,434.02)	(2,463,183,783.07)
Түрээсийн орлого		
Хүүний орлого	763,648.91	1,534,604.15
Бусад орлого	2,072,026,525.95	2,368,680,379.89
Борлуулалт, маркетингийн зардал	1,993,630.96	2,625,670.64
Ерөнхий ба удирдлагын зардал	644,714,185.72	685,487,721.31
Санхүүгийн зардал	9,602,729.32	
Бусад зардал	113,787,565.19	94,586,503.30
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	206,747.51	85,908.92
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)	(288,470,909.91)	(246,437,423.65)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(814,395,532.75)	(1,122,020,209.01)
Орлогын татварын зардал	76,364.89	153,460.42
Татвар дараах ашиг (алдагдал)	(814,471,897.64)	(1,122,173,669.43)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(814,471,897.64)	(1,122,173,669.43)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	(814,471,897.64)	(1,122,173,669.43)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
2018 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл	8,337,595,020.45	3,056,979,095.13		(11,016,971,581.75)	377,602,533.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(166,534,483.78)	(166,534,483.78)
Залруулсан үлдэгдэл	8,337,595,020.45	3,056,979,095.13	-	(11,183,506,065.53)	211,068,050.05
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(814,471,897.64)	(814,471,897.64)
Бусад дэлгэрэнгүй орлого					0.00
Өмчид гарсан өөрчлөлт			1,655,056,500.00		1,655,056,500.00
Зарласан ногдол ашиг					0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1,751,097,157.36			1,751,097,157.36
2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(11,997,977,963.17)	2,802,749,809.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				134,146,847.21	134,146,847.21
Залруулсан үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(11,863,831,115.96)	2,936,896,656.98
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,122,173,669.43)	(1,122,173,669.43)
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	(12,986,004,785.39)	1,814,722,987.55

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

<u>Үзүүлэлт</u>	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31 (төгрөгөөр)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн	4,554,081,266.10	5,490,792,985.17
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,773,515,688.62	3,612,765,967.89
Татаас санхүүжилтийн орлого	1,600,000,000.00	1,600,021,501.00
Бусад мөнгөн орлого	180,565,577.48	278,005,516.28
Мөнгөн зарлагын дүн	4,420,130,444.01	4,637,556,114.95
Ажиллагчдад төлсөн	1,791,893,334.27	1,855,492,385.16
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	499,478,010.00	416,900,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	681,312,159.85	838,555,219.01
Ашиглалтын зардалд төлсөн	249,249,892.21	318,361,450.04
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	489,669,545.85	769,026,020.63
Хүүний төлбөрт төлсөн	6,755,384.56	11,624,958.63
Татварын байгууллагад төлсөн	424,016,654.38	118,941,239.91
Даатгалын төлбөрт төлсөн	4,327,780.00	3,410,000.00
Бусад мөнгөн зарлага	273,427,682.89	305,244,841.57
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	133,950,822.09	853,236,870.22
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	63,263,648.91	4,737,148.15
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	62,500,000.00	3,202,544.00
Хүлээн авсан ноогдол ашиг	763,648.91	1,534,604.15
Мөнгөн зарлагын дүн	186,944,747.83	954,555,290.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	186,944,747.83	879,755,290.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		800,000.00
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		74,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(123,681,098.92)	(949,818,141.85)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,340,483,898.81	1,385,345,966.39
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,340,483,898.81	1,385,345,966.39
Мөнгөн зарлагын дүн	1,360,627,770.17	1,312,299,694.79
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,360,627,770.17	1,312,299,694.79
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,143,871.36)	73,046,271.60
Валютын ханшийн зөрүү	240,031.03	85,908.92
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(9,634,117.16)	(23,449,091.11)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,731,258.23	31,097,141.07
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,097,141.07	7,648,049.96

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код
2020.03.13			САГ-2020/36/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	25.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Банзрагч, С.Гэрэлт-Од
2	Зардлыг буруу ангилж нүүрс тээврийн зардлыг нүүрсний өртөгт шингээж бүртгээгүй байна.	18.9	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Банзрагч, С.Гэрэлт-Од
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрсөн	5.9	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Банзрагч, С.Гэрэлт-Од
4	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Л.Банзрагч, С.Гэрэлт-Од
	Дүн	49.8			